



МОНГОЛ УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАР ДАХЬ ТОЙРОГ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ



© 2025 Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яам

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай-3, Засгийн газрын 12 дугаар байрны 4 дүгээр давхар

Хянан тохиолдуулсан:

Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яам, байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц. Уранчимэг

Азийн Хөгжлийн Банк, Жендэрийн албаны Нийгмийн хөгжил, жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Цолмон

Тойрог эдийн засаг ба ногоон бизнесийн чиглэлд бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг чадавхжуулах нь төсөл

Зохицуулагч Ж.Чойханд

Төслийн зөвлөх Б.Оюунгэрэл

Энэхүү товхимлыг Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яамны захиалгаар, Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр хэрэгжиж буй ТТ-6883 REG: Зүүн Азид жендэрийн тэгш байдлыг хурдасгах – Хүртээмжтэй, ногоон сэргэлтийн төлөө бүсийн техникийн туслалцааны төслийн хүрээнд боловсруулсан “Аялал жуулчлалын салбарын тойрог эдийн засгийн цогц үнэлгээ”-ний үр дүн дээр үндэслэн боловсруулав.

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт.....	1
1 Удиртгал.....	2
2 Аялал жуулчлалын салбар дах тойрог эдийн засгийн хэлхээнд оролцогчид.....	4
2.1 Тойрог эдийн засаг дахь оролцогч талуудын оролцоо.....	4
2.1.1 Төрийн байгууллагууд.....	4
2.1.2 Хувийн хэвшлийн байгууллагууд.....	5
2.1.3 Иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ).....	5
2.1.4 Санхүүгийн байгууллага.....	5
2.1.5 Судалгаа, боловсролын байгууллагууд.....	5
2.1.6 Олон улсын хөгжлийн түншүүд.....	5
2.1.7 Эцсийн хэрэглэгч, аялагчид.....	5
2.2 Дүгнэлт.....	6
3 Тойрог эдийн засгийн тухай ойлголт ба ач холбогдол.....	7
4 Нөхцөл байдлын үнэлгээ.....	8
5 Судалгааны үр дүнгийн нэгтгэл: 5 бүлгийн дүгнэлт.....	9
6 Эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан зөвлөмж.....	10
7 Зөвлөмжийн хэрэгжилтийн алхмууд.....	11
8 Гүйцэтгэсэн зөвлөх үйлчилгээний үр дүн (TA Outcome).....	12
9 Эцсийн дүгнэлт.....	13

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

МУ	Монгол Улс
БЖДБЭ	Бичил, жижиг, дунд бизнес эрхлэгч
БОУАӨЯ	Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яам
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
НҮБХХ	Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөр
ТЭЗ	Тойрог эдийн засаг
ХББОСЯ	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам
ХХААХҮЯ	Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн яам
ШУА	Шинжлэх ухааны академи
CAREC	Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны орнууд

1 УДИРТГАЛ

Аялал жуулчлалын салбар нь Монгол Улсын хувьд эдийн засгийн өсөлт, ажлын байр нэмэгдүүлэх, бүс нутгийн хөгжилд хувь нэмэр оруулахын зэрэгцээ байгаль орчин, соёлын өвийг хамгаалах чухал үүрэгтэй. Гэвч энэхүү салбар нь ус, эрчим хүчний өндөр хэрэглээтэй, байгалийн унаган төрх, нүүдэлчин малчдын ахуй амьдралыг түшиглэсэн хязгаарлагдмал бүтээгдэхүүн, үйлчилгээтэй, улирлын чанартай үйл ажиллагаа давамгайлдаг онцлогтой. Иймд “Тойрог эдийн засаг” (ТЭЗ)-ийн зарчмуудыг нэвтрүүлж, тус салбарыг гадаад валютын эх үүсвэр тогтвортой ногоон бизнесийн салбар болгон өрсөлдөх чадвар, нөөцийн хэмнэлт, хог хаягдлын хэмжээг бодитоор бууруулах стратегийн шийдэлтэй эдийн засгийн томоохон салбар болгон бойжуулах бүрэн боломжтой байна.

Дэлхий нийт ТЭЗ-ийн загвар руу шилжих шилжилтийг эрчимжүүлж буй энэ үед Монгол Улсад аялал жуулчлалын салбарт энэхүү шинэчлэлийг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага, бодит боломж оршиж байна. Энэхүү товхимол нь Азийн Хөгжлийн Банкны санхүүжилттэй, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны хэрэгжүүлж буй “Зүүн Азид жендэрийн тэгш байдлыг нэмэгдүүлэх нь” (RETA 6883) техникийн туслалцааны хүрээнд боловсруулагдсан болно. Тодруулбал, аялал жуулчлалын салбар дахь эмэгтэй удирдлагатай, эмэгтэйчүүдийн оролцоотой бизнесүүдийн ногоон шилжилтийг дэмжих дэд төслийн хүрээнд хийгдсэн судалгаа, дүн шинжилгээ, бодлогын зөвлөмжийг энэхүү товхимлоор дамжуулан олон нийтэд хүргэх зорилготой юм.

Төслийн зорилго “Аялал жуулчлалын салбар дах хоол хүнс болон сав баглаа боодлын чиглэлд дэх тойрог эдийн засаг, ногоон технологийн талаарх мэдлэг, чадавхыг бэхжүүлэх замаар жендерийн тэгш байдлыг дэмжих”						
Үр дүн Бүтээгдэхүүн	1. МУ-ын тодорхой салбаруудад тойрог эдийн засгийн хандлагыг хэрэгжүүлэх боломж, саад бэрхшээлийн талаар цогц үнэлгээг хийж гүйцэтгэх.		2. Зорилтот салбарын бизнес эрхлэгчдийн тойрог эдийн засгийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлж, чадавхыг бэхжүүлэх.		3. Үндэсний болон ОУ-ын түвшний бодлогын хэлэлцүүлэг, туршлага солилцох арга хэмжээг зохион байгуулах.	
Гол үйл ажиллагаа	1. Тойрог эдийн засгийн чадавхын өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх, хэрэгцээ тодорхойлох судалгааг хийх.	1.2. Зорилтот салбарт тойрог эдийн засгийн хандлагыг нэвтрүүлэх, өргөжүүлэхэд чиглэсэн бодлогын үнэлгээ гүйцэтгэх.	2.1. Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг ногоон бизнесийн туршлагыг ашиглах талаар мэдлэгийг нэмэгдүүлэх.	2.2. Ногоон бизнесийн талаар шилдэг шийдэл бүхий 15 бизнес эрхлэгчдэд зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэх.	3.1. Ногоон болон тойрог эдийн засгийн талаар үндэсний түвшний бодлогын хэлэлцүүлэг зохион байгуулах	3.2. Ногоон болон тойрог эдийн засгийн талаар олон улсын CAREC орнуудтай хэлэлцүүлэг зохион байгуулах.
Гарсан үр дүн	1.1.1. Бизнесийн өнөөгийн нөхцөл байдал, суурь үзүүлэлтүүд тодорхойлогдсон 1.1.2. Сургалт, ментор, дэмжлэгийн хэрэгцээг тодорхойлсон.	1.2.1. Бодлогын Үнэлгээ хийгдсэн. 1.2.2. Оролцогч талуудын шинжилгээ гарсан. 1.2.3. Салбарын Үнэлгээ хийгдсэн.	2.1.1. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө гарсан. 2.1.2. Сургалт нийт хүнийг хамарсан. 2.1.3. Сургалтын өмнөх, дараах үнэлгээ хийгдсэн 2.1.4 Үр дүнгийн Үнэлгээ гарсан.	2.2.1. Сонгон шалгаруулалтын удирдамж батлагдсан. 2.2.2. Сонгон Шалгаруулалт хийгдсэн. 2.2.3. Менторын Хөтөлбөр зохион байгуулагдсан. 2.2.4. Шалгарсан бизнес эрхлэгч нарт грантын дэмжлэг үзүүлж үр дүнд хүрсэн.	3.3.1.Бодлогын хэлэлцүүлэг зохион байгуулах бэлтгэл ажлууд хийгдсэн. 3.3.2. Үндэсний бодлогын хэлэлцүүлэг зохион байгуулагдсан.	3.2.1. Виртуал Хэлэлцүүлэг амжилттай хийгдсэн. 3.2.2. CAREC-ийн сонгосон улс руу буюу БНХАУ-ын Өмнөд хэсэг, Хонгконг туршлага судлах аялал. Хэлэлцүүлэг болон туршлага солилцох аяллын үр дүнд тулгуурлан хэвлэн нийтлүүлэх мэдлэгийн бүтээгдэхүүн боловсруулна.

2.1.2 Хувийн хэвшлийн байгууллагууд

Бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчид (БЖДБЭ) нь ТЭЗ-ийн анхдагч хэрэгжүүлэгчид. Тэд бүтээгдэхүүнээ дахин загварчлах, байгальд ээлтэй савлагаа нэвтрүүлэх, хаягдлыг багасгах технологи нэвтрүүлэх замаар өөрийн үйл ажиллагааг тойрогт шилжүүлж эхэлж байна. Судалгаагаар тэдний дийлэнх нь “хэрэглээний дараах нөхөн сэргээх” болон “тойрог нийлүүлэлт рүү шилжих” чадавхыг хөгжүүлэх хэрэгцээтэй байгааг тогтоожээ.

2.1.3 Иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ)

ИНБ-ууд нь олон нийтэд зориулсан сургалт, мэдээлэл түгээх, хяналт-шинжилгээ хийх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр чухал үүрэг гүйцэтгэж байна. “Ногоон санхүүжилтийн холбоо”, “Тогтвортой санхүүгийн холбоо” зэрэг байгууллагууд ногоон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн зөвлөмж, дэмжлэгийг санал болгодог.

2.1.4 Санхүүгийн байгууллагууд

Үндэсний болон олон улсын банкууд, даатгалын компаниуд, санхүүгийн зуучлагчид ТЭЗ-ийн шилжилтийг дэмжих хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж, хөрөнгө оруулалтын схемийг боловсруулж хэрэгжүүлдэг. Монголд хэрэгжиж буй “Ногоон зээлийн сан” нь ТЭЗ-т чиглэсэн үйл ажиллагааг шууд дэмжиж буй жишээ юм.

2.1.5 Судалгаа, боловсролын байгууллагууд

Монгол Улсын их дээд сургуулиуд, судалгааны төвүүд (жишээлбэл, IRIM, Монголын ШУА, Тогтвортой хөгжлийн хүрээлэн) нь ТЭЗ-ийн талаарх мэдлэг, мэдээллийг үндэслэлтэй судалгаа, дүн шинжилгээгээр хангадаг. Түүнчлэн сургагч багш бэлтгэх, сургалтын контент боловсруулах чиглэлээр үнэтэй хувь нэмэр оруулж байна.


2.1.6 Олон улсын хөгжлийн түншүүд

Азийн Хөгжлийн Банк, НҮБХХ, Европын Холбоо зэрэг хөгжлийн түншүүд нь техникийн туслалцаа, чадавх бэхжүүлэх төсөл, бодлогын зөвлөмжөөр дамжуулан орон нутгийн болон үндэсний хэмжээнд ТЭЗ-ийн хэрэгжилтийг дэмжиж байна. Жишээлбэл, “ТА-6883” бүсийн хөтөлбөр нь жөндөрт суурилсан ТЭЗ-ийн шилжилтийг дэмжихэд чиглэсэн бөгөөд аялал жуулчлалын салбарт амжилттай хэрэгжиж байна.

2.1.7 Эцсийн хэрэглэгч, аялагчид

Хэрэглэгчийн хандлага өөрчлөгдөхгүй бол ТЭЗ бодит амьдралд хэрэгжихгүй. Судалгаанд оролцсон аялагчдын 78% нь байгальд ээлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээг сонгох хандлагатай байгаагаа илэрхийлсэн нь зах зээлийн эрэлт хэрхэн өөрчлөгдөж байгааг харуулж байна.

Зураг 2. Оролцогчдын ашиг сонирхол, нөлөө




2.2 Дүгнэлт

Тойрог эдийн засаг бол зөвхөн үйлдвэрлэлийн шинэчлэл бус, бүх талын оролцоо, хариуцлагад тулгуурласан нийгэм-эдийн засгийн шинэчлэл юм. Монгол Улсад ТЭЗ-ийг тогтвортой хэрэгжүүлэхийн тулд оролцогч талуудын чиг үүргийг илүү тодорхой болгож, тэдний хоорондын уялдаа холбоог гүнзгийрүүлэх шаардлагатай байна. Үүний тулд бодлогын зохицуулалт, хамтарсан үйл ажиллагаа, олон талт түншлэл зайлшгүй юм.

3 ТОЙРОГ ЭДИЙН ЗАСГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ БА АЧ ХОЛБОГДОЛ

Тойрог эдийн засгийн тухай үндсэн ойлголт, түүний эдийн засгийн үнэ цэнийг Монгол улсын байгаль орчныг хамгаалах эдийн засаг татварын бодлого эрх зүй, бизнесийн орчинд нэвтрүүлж, байгалийн нөөцийг үр ашигтай ашиглах, хог хаягдлыг багасгах, бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийг уртасгах зорилготой тогтолцоог буй болгож төлөвшүүлэх тухай ойлголт юм. Энэхүү тогтолцоо нь “авах - ашиглах - хаях” уламжлалт шугаман эдийн засгийн загвар сэтгэлгээнээс ангижрах ногоон шилжилтийг хийх ач холбогдолтой гэж үзсэн бөгөөд манай улсад аялал жуулчлалын салбар нь ус, эрчим хүчний хэрэглээ ихтэй, байгалийн нөөцөд түшиглэсэн, ашиглалт өндөртэй эдийн засгийн салбарт тооцогдох тул ТЭЗ-ийг үндсэн ойлголтуудыг хэрэгжүүлэх, тэнд аж ахуй эрхлэгчдэд энэ чиглэлийн сургалт мэдлэг олгох нь стратегийн өндөр ач холбогдолтой ажил юм.

Зураг 3. Шугаман ба тойрог эдийн засгийн ерөнхий дүрслэл



4 НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Монгол Улсад тойрог эдийн засгийг хэрэгжүүлэх анхны бодлогын алхмууд хийгдэж байгаа хэдий ч аялал жуулчлалын салбарт түүний нэвтрүүлэлт удаашралтай байна. “Цогц үнэлгээний тайлан”-д дурдсанаар ТЭЗ-ийн зарчмыг аялал жуулчлалын нэмүү өртгийн сүлжээнд шингээх бодлогын уялдаа сул, зохицуулалтын дэмжлэг болон мэдээллийн хүртээмж хомс, мөн жендэрийн тэгш бус байдал, санхүүжилтийн хязгаарлалт зэрэг олон талт сорилт байсаар байна.

Хүний нөөцийн чадавх, байгальд ээлтэй технологийн нэвтрэлт, бүтээгдэхүүн үйлчилгээний амьдралын мөчлөгт тохирсон шийдлүүд дутмаг байгаа нь аялал жуулчлалын салбарт хог хаягдлын хэмжээ нэмэгдэх, нөөцийн үр ашиг буурах, орон нутгийн оролцоо хангалтгүй байх зэрэг хүндрэл үүсгэж байна.

Мөн энэ төслийн хүрээнд тойрог эдийн засгийн оролцогчдыг тодорхойлж, тэдний зураглалыг гаргасан.

Цаашид Монгол Улсын аялал жуулчлалын салбарт ТЭЗ-ийг хэрэгжүүлэхэд дараах чиглэлээр анхаарал хандуулах шаардлагатай байна:

- Бодлогын түвшинд ТЭЗ-ийн зарчмыг тусгасан тусгай хөтөлбөр, стандарт, шалгуур үзүүлэлт боловсруулах;
- Ногоон бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжих татварын болон санхүүгийн урамшууллын тогтолцоог бүрдүүлэх;
- Орон нутгийн жижиг, дунд бизнес эрхлэгчдэд чиглэсэн сургалт, мэдээлэл түгээх системийг сайжруулах;
- Эмэгтэй удирдлагатай БЖДБЭ-үүдийн оролцоог нэмэгдүүлэх, жендэрт суурилсан хандлагыг бодлогын төвшинд шингээх.

Кейс жишээ 1: “Эко жуулчлалын гэр буудал”, Архангай аймаг

Байгальд ээлтэй, тойрог эдийн засгийн зарчимд тулгуурласан амьдралын хэв маягийг хэрэгжүүлэгч гэр буудлын эзэн Б.Мөнхзаяа нь дахин ашигласан тавилга, хог ангилан ялгах систем, нутгийн гар урлал ашиглан жуулчдад үйлчилдэг. Түүний туршлага нь ТЭЗ-ийн зарчмыг хөдөө орон нутагт амжилттай хэрэгжүүлж болдгийг харуулж байна.

“Манай бүс нутгийн аялал жуулчлал зөвхөн жуулчин татах биш, байгаль орчноо хайрлах, залуу үеийнхэнд эерэг жишээ үзүүлэх хэрэгтэй гэж боддог.”

Эмэгтэй бизнес эрхлэгчийн төлөөлөл, Архангай аймаг

5 СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН НЭГТГЭЛ

Цогц үнэлгээний судалгаануудын үр дүнд тулгуурлан, аялал жуулчлалын салбар дахь тойрог эдийн засгийг хэрэгжүүлэх боломж, сорилт, бэлэн байдлыг дараах 5 үндсэн чиглэлээр нэгтгэн дүгнэв.

Хүрээ	Гол давуу талууд	Сорилт болон боломжууд
1. Бодлого	- ТЭЗ-ийн үзэл баримтлал хөгжлийн бодлогод тусгагдаж эхэлсэн “Алсын хараа 2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”-д ТЭЗ-тэй уялдсан зорилтууд орсон	- Салбар дундын уялдаа хангалтгүй - Аялал жуулчлалын салбарт ТЭЗ-т чиглэсэн нарийвчилсан бодлого, хэрэгжилтийн хяналт-шинжилгээний тогтолцоо дутмаг
2. Хувийн хэвшил	- БЖДБЭ-үүдийн оролцох сонирхол өндөр - Зарим бүс нутагт ногоон бизнесийн туршлага бий болсон	- Хувийн хэвшлийн дийлэнх нь ТЭЗ-ийн ойлголт сул - Санхүүгийн эх үүсвэр хязгаарлагдмал, хөрөнгө оруулалт татах чадамж сул
3. Технологи	- Эко инновац, ногоон технологийн санаачилга нэмэгдэж байгаа (жишээ: хаягдал ангилалт, дахин боловсруулах системүүд) - Гарааны бизнесүүд өсөж байна	- Технологийн хүртээмж, сургалт, мэдээлэл түгээх систем сул - Техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх дэмжлэг муу
4. Жөндөрийн тэгш байдал	Эмэгтэй удирдлагатай бизнесүүд ТЭЗ-ийн зарчмыг амжилттай туршиж буй жишээтэй (жишээ: Архангайн “Эко гэр буудал”)	- Бодлогын түвшинд жөндөрийн уялдаа сул - Жөндөрт мэдрэмтгий сургалт, санхүүжилтийн хөтөлбөрүүд хангалтгүй
5. Хөрөнгө оруулалт	- Ногоон зээл, грантын зарим боломж бий (жишээ: ногоон зээлийн сан, донорын хөтөлбөрүүд) - Санхүүгийн хүртээмж нэмэгдүүлэх санаачилга хийгдэж байна	- Ногоон бизнес рүү чиглэсэн татварын урамшуулал сул - Хөрөнгө оруулалтын орчны тогтвортой байдал, эрсдэлийн баталгаа хангалтгүй

6 ЭМЭГТЭЙ БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ

Тус төслөөс Монгол Улсад жөндөрт суурилсан ногоон эдийн засгийн шилжилтийг дэмжих хүрээнд, аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж буй эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан дараах чиглэлийн бодлогын болон практик арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзсэн.


- I. Мэдлэг, чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор эмэгтэй удирдлагатай бичил, жижиг, дунд бизнесүүдэд зориулсан ТЭЗ, эко инновац, ногоон бизнесийн талаарх сургалтыг бүс нутагт шаталсан байдлаар зохион байгуулах шаардлагатай. Энэ хүрээнд “train-the-trainers” аргачлалаар орон нутгийн сургагч багш бэлтгэж, жөндөрт мэдрэмтгий сургалтын агуулгыг түгээмэл болгох хэрэгтэй.
- II. Санхүүгийн хүртээмжийг сайжруулахын тулд ТЭЗ-ийн зарчимд тулгуурласан эмэгтэй удирдлагатай бизнесүүдэд зориулсан ногоон зээл, буцалтгүй тусламж, баталгаат хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн хөгжүүлэх хэрэгцээ их байна. Үүнийг хангахын тулд санхүүгийн байгууллагуудад жөндөрт суурилсан эрсдэлийн үнэлгээний аргачлал нэвтрүүлэх, татварын урамшууллын тогтолцоог бий болгох нь чухал юм.
- III. Зах зээлд нэвтрэх сувгуудыг тэлэх нь эмэгтэй бизнес эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ. Үүнд брэнд хөгжүүлэлт, сав баглаа боодлын шийдлийг сайжруулах зөвлөмж өгөхөөс гадна дотоодын болон олон улсын үзэсгэлэн, цахим худалдааны платформ ашиглан бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах ажлууд багтана. Мөн хамтын ажиллагааны сүлжээг бий болгох, бүс нутгийн хоршоодыг дэмжих нь үр нөлөөтэй.
- IV. Байгальд ээлтэй технологи нэвтрүүлж буй эмэгтэй бизнес эрхлэгчдэд ухаалаг шийдэл, хог хаягдлыг бууруулах технологи, сэргээн засварлах үйлдвэрлэл зэрэг шинэ санаачилгуудыг турших, түгээх хэрэгцээ бий. Инкубатор, акселератор хөтөлбөрөөр дамжуулан инновацлаг стартапуудыг дэмжих нь энэхүү шилжилтийг хурдасгана.

7 ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН АЛХМУУД

Тойрог эдийн засгийг (ТЭЗ) амжилттай хэрэгжүүлэхийн тулд үндэсний болон орон нутгийн түвшинд шат дараатай, системтэй аргачлал шаардлагатай. Юуны өмнө тухайн салбар, бүс нутгийн онцлогт нийцүүлэн ТЭЗ хэрэгжүүлэх шаардлагыг тодорхойлж, боломж ба бэрхшээлийг үнэлэх нь чухал юм. Үүний дараа бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлэх, салбар хоорондын зохицуулалтыг сайжруулах, болон институтийн бүтэц зохион байгуулалтыг тодорхойлох шаардлагатай.

Монгол Улсад ТЭЗ-ийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэрийг татах механизмыг бүрдүүлэхийн зэрэгцээ олон нийтийн оролцоо, бизнес эрхлэгчдийн идэвхтэй оролцоо, мэдлэг чадавхыг дээшлүүлэх үйл ажиллагаа чухал байр суурь эзэлж байна. Эцэст нь, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бий болгож, үр дүнг бодитой үнэлж, цаашдын үйл ажиллагаанд суурь болгон ашиглах шаардлагатай байгааг уг төслийг хэрэгжүүлэх явцад илүү тодорхой болсон.

Зураг 4. Зөвлөмжийг хэрэгжүүлэх алхмууд



ЭЦСИЙН ДҮГНЭЛТ

Монгол Улсын аялал жуулчлалын салбарт ТЭЗ-ийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд эмэгтэй бизнес эрхлэгчдийг онцгойлон дэмжсэн, жендэрийн мэдрэмжтэй, ногоон инновацад суурилсан бодлого, хөрөнгө оруулалт, чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа хэрэгтэй байна. ТЭЗ нь зөвхөн байгаль хамгаалах арга зам бус, бизнес эрхлэгчдэд шинэ боломж, эдийн засгийн тогтвортой өсөлтийг авчрах хөшүүрэг болох юм.

8 ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Төслийн хүрээнд бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн ногоон сэргэлтийн талаарх мэдлэг, чадавх мэдэгдэхүйц нэмэгдэж, COVID-19-ийн дараах тогтвортой сэргэлтэд бизнес эрхлэгч нар идэвхтэй хувь нэмэр орууллаа. 420 эмэгтэй бизнес эрхлэгчийг чадавхжуулж, сургалт, менторшипд хамруулсан бөгөөд оролцогчдын 70% нь ногоон бизнесийн дадлыг хэрэгжүүлсэн.

1-р бүрэлдэхүүн хэсэг:

Төслийн эхэнд аялал жуулчлалын салбар дахь тойрог эдийн засгийн талаар иж бүрэн үнэлгээ хийж, дараагийн үйл ажиллагааны суурь болгов. Үнэлгээ нь дараах гурван үндсэн хэсгээс бүрдсэн:

5. **Бодлогын үнэлгээ** – Аялал жуулчлал, ялангуяа хүнс, сав баглаа боодлын салбарт хамаарах төрийн бодлого, хөгжлийн зорилтуудыг тодорхойлон, шийдвэр гаргагчдад зөвлөмж өгсөн.
6. **Бэлэн байдлын үнэлгээ** – Хоол хүнс, ундаа, байрны үйлчилгээний үнэт сүлжээнд оролцогч үйлчилгээ үзүүлэгчид болон үйлдвэрлэгчдийн ТЭЗ-ийн стратеги нэвтрүүлэх чадавхыг үнэлсэн.
7. **Оролцогч талуудын үнэлгээ** – Аялал жуулчлалын салбар дахь хамтын ажиллагааг дэмжихэд ТЭЗ ямар үүрэг гүйцэтгэх талаар оролцогчдын үзэл бодлыг авч үзсэн. Ялангуяа эмэгтэйчүүдийн удирдсан БЖДБ-үүдийн ТЭЗ-д нэвтрэх ашиг тус болон нөлөөллийг онцгойлон судалсан.



2-р бүрэлдэхүүн хэсэг:

ТЭЗ-ийг хэрэгжүүлэхэд БЖДБ-үүдийг дэмжих зорилгоор **Бодлогын лабораторийн ажлын хэсэг** байгуулсан. Энэхүү хэсэг нь оролцогч талуудтай бодлогын уулзалтууд зохион байгуулж, жендэрийн мэдрэмжтэй бодлого боловсруулахыг дэмжсэн. Шийдвэр гаргагчдын сайн туршлагаас суралцах боломжоор БНХАУ-ын Шэньжэнь, Хонг-Конг-т судалгааны аялал зохион байгуулсан бөгөөд дараа нь CAREC-ийн гишүүн орнуудын дунд жендэрт суурилсан тогтвортой хөгжлийн талаар цахим бага хурал хийсэн. Эцэст нь Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яаманд -д бодлогын зөвлөмжийг боловсруулж, хүргүүлсэн.



3-р бүрэлдэхүүн хэсэг:

Эмэгтэйчүүдийн удирдсан БЖДБ-үүдийг чадавхжуулах үйл ажиллагааг ямар нэг томоохон худалдан авалтгүйгээр амжилттай хэрэгжүүлсэн.

- Сургалтыг нийт 15 цагийн хугацаатай 5 хичээлийн (3 танхимын, 2 цахим) хэлбэрээр зохион байгуулсан.
- Улаанбаатар, Хөвсгөл, Архангай аймгаас 420 эмэгтэй бизнес эрхлэгч оролцсон бөгөөд тохиолдлын судалгаа, бүлгийн дасгал, хэлэлцүүлэг зэрэг харилцан үйлдэлд суурилсан арга зүйг ашигласан.
- Менторшип нь үндэсний болон олон улсын мэргэжилтнүүдийн удирдлага дор 6 удаагийн онлайн уулзалтаар хийгдсэн бөгөөд ТЭЗ-ийн зарчим, тогтвортой бизнес төлөвлөлт, ногоон санхүүжилтийн сэдвийг хамарсан.

